

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/015-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Сүхбаатар сум
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх
Утас: 70363040 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Отгонбаяр
Утас: 70363036 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn
Аудитор: Ж.Цогт
Утас: 70363047 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогоос 3,319,972.3 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдэл 656,299.3 мянган төгрөг, ОНХС-ийн эхний үлдэгдлээс 582,137.9 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 1,216,490.5 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 45049,5 мянган төгрөг, ХХС-ийн оны эхний үлдэгдлээс 78258,4 мянган төгрөг, зэрэг нийт 5,819,949.5 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд тус сумын нутаг дэвсгэрт гарсан ойн түймрийг унтраах үйл ажиллагаанд зориулан иргэд, аж ахуйн нэгжээс 64,291.0 мянган төгрөгийн мөнгөн хандив, тайлант оны төсвөөс 33,978.6 мянган төгрөгийг бүрдүүлж, 69,606.0 мянган төгрөгийг тээвэр, шатахуунд, 91,380.2 мянган төгрөгийг хүнсэнд, 7,525.0 мянган төгрөгийг сэлбэг хэрэгсэлд, 5,345.0 мянган төгрөгийг бусад хэрэгцээт зүйлсэд зэрэг нийт 173,856.2 мянган төгрөгийг зарцуулсан ба 75,586.6 мянган төгрөгийн өр төлбөр /тээвэр, шатахуунд 42,102.4 мянган төгрөг, хүнсэнд 33,484.2 мянган төгрөг/ үүссэн байна.

Бусад асуудлын хэсэг

Хүдэр сумын Засаг дарга нь тайлант онд 20 зорилт, 164 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.4 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БАТМӨНХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,247,075.2	3,249,512.2
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,488,556.2	1,040,686.6
3	АВЛАГА	111,186.7	193,175.8
4	БАРАА МАТЕРИАЛ	647,332.3	2,015,649.8
5	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,331,352.7	6,574,938.2
6	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,331,352.7	6,574,938.2
7	Биет хөрөнгө	5,246,153.6	6,488,692.4
8	Биет бус хөрөнгө	85,199.1	86,245.8
9	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	7,578,427.9	9,824,450.4
10	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,538.0	224,215.0
11	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,538.0	224,215.0
12	Өглөг	1,538.0	224,215.0
13	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,576,889.9	9,600,235.4
14	1 Засгийн газрын хувь оролцоо	7,576,889.9	9,600,235.4
15	Засгийн газрын оруулсан капитал	287,430.8	286,195.8
16	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	117,805.0	119,040.0
17	Хуримтлагдсан үр дүн	6,755,781.8	8,780,863.9
18	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	415,872.4	414,135.7
19	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	7,578,427.9	9,824,450.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,503,734.4	8,460,198.9
2	ТАТВАРЫН ОРЛОГО	1,848,144.8	2,473,541.7
3	Орлогын албан татвар	904,988.2	1,081,038.1
4	Хувь хүний орлогын албан татвар	948,923.2	1,129,071.6
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(43,935.0)	(48,033.5)
6	Хөрөнгийн албан татвар	83,948.2	63,943.4
7	Бусад татвар, төлбөр, хураамж	859,208.4	1,328,560.2
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,708,789.0	5,986,657.2
9	Тусламжийн орлого	-	66,865.4

10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	946,800.6	-
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,978,109.6	6,392,519.0
12	УРСГАЛ ЗАРДАЛ	3,818,984.9	5,722,146.8
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,769,859.1	5,283,380.29..3
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	959,351.8	1,110,583.2
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,961.4	139,994.8
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	370,351.8	378,217.5
17	Хангамж, бараа материалын зардал	50,653.7	100,130.7
18	Нормативт зардал	500.0	2,939.9
19	Эд хогшил, урсгал засварын зардал	81,165.3	55,471.1
20	Томилолт, зочны зардал	9,251.0	13,062.6
21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	485,808.1	517,740.3
22	Бараа үйлчилгээний бусад зардал	684,816.0	2,965,240.2
23	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,049,125.8	438,766.5
24	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	159,124.6	670,372.2
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	525,624.8	2,067,679.9
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	3,960.0
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	155,546.2	46,557.7
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(155,546.2)	(42,597.7)
29	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	370,078.6	2,025,082.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,198,731.3	7,198,731.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(54,904.0)	(54,904.0)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,143,827.3	7,143,827.3
4	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	8,080.0	8,080.0
5	Өмчид гарсан өөрчлөлт	54,904.0	54,904.0
6	Тайлант үеийн үр дүн	370,078.6	370,078.6
7	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,576,889.9	7,576,889.9
8	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,576,889.9	7,576,889.9
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,576,889.9	7,576,889.9
10	Өмчид гарсан өөрчлөлт	(1,736.7)	(1,736.7)
11	Тайлант үеийн үр дүн	2,025,082.2	2,025,082.2

12	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	9,600,235.4	9,600,235.4
----	---	-------------	-------------

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,272,985.2	6,749,839.3
2	ТАТВАРЫН ОРЛОГО	1,848,144.8	2,473,541.7
3	Орлогын албан татвар	904,988.2	1,081,038.1
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(43,935.0)	(48,033.5)
5	Хөрөнгийн албан татвар	83,948.2	63,943.4
6	Бусад татвар, төлбөр, хураамж	859,208.4	1,328,560.2
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	34,552.6	45,230.8
8	Газрын төлбөр	309,497.3	345,609.5
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	515,158.4	937,719.9
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,478,039.8	4,276,297.6
11	Нийтлэг татварын бус орлого	1,478,039.8	1,293,581.0
12	Тусламжийн орлого	-	1,766,226.1
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	1,216,490.5
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	946,800.6	-
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,421,947.3	5,252,845.4
16	УРСГАЛ ЗАРДАЛ	3,421,947.3	5,252,845.4
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,372,821.5	4,814,078.8
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,129,641.3	1,324,910.8
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	178,005.3	139,994.8
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	377,891.5	383,327.2
21	Хангамж, бараа материалын зардал	146,244.7	143,243.9
22	Нормативт зардал	500.0	2,939.9
23	Эд хогшил, урсгал засварын зардал	109,690.2	118,815.5
24	Томилолт, зочны зардал	9,251.0	12,152.6
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	193,305.3	226,299.4
26	Бараа үйлчилгээний бусад зардал	228,292.2	2,462,394.7
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,049,125.8	438,766.6

28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	851,037.8	1,496,993.9
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	796,495.5	1,834,863.5
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	796,495.5	1,834,863.5
31	Дотоод эх үүсвэрээр	796,495.5	1,834,863.5
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(796,495.5)	(1,834,863.5)
33	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	110,000.0
34	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(110,000.0)
35	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	54,542.3	(447,869.6)
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,434,013.9	1,488,556.2
37	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,488,556.2	1,040,686.6

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,334,478.6	5,352,379.6	982,099.0	84.5
2	Татварын орлого	2,608,501.6	2,473,541.7	134,959.9	94.8
3	Орлогын албан татвар	1,031,071.5	1,129,071.6	- 98,000.1	109.5
4	Хувь хүний орлогын албан татвар	1,076,071.5	1,129,071.6	- 53,000.1	104.9
5	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	942,571.5	1,040,624.7	- 98,053.2	110.4
6	Үйл ажиллагааны орлого	13,300.0	37,738.5	- 24,438.5	283.7
7	Хөрөнгийн орлого	107,700.0	41,689.3	66,010.7	38.7
8	Хөрөнгө борлуулсны орлого	12,500.0	9,019.1	3,480.9	72.2
9	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	- 45,000.0	- 48,033.5	3,033.5	106.7
10	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	- 45,000.0	- 48,033.5	3,033.5	106.7
11	Хөрөнгийн албан татвар	69,778.5	63,943.4	5,835.1	91.6
12	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	21,975.2	20,494.0	1,481.2	93.3
13	Бууны албан татвар	2,890.0	2,955.0	- 65.0	102.2
14	Малд ногдуулах албан татвар	44,913.3	40,494.4	4,418.9	90.2
15	Бусад татвар, төлбөр, хураамж	1,507,651.6	1,328,560.2	179,091.4	88.1
16	Бусад нийтлэг төлбөр, хураамж	41,528.0	45,230.8	- 3,702.8	108.9
17	Улсын тэмдэгтийн хураамж	32,700.0	33,902.3	- 1,202.3	103.7
18	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	3,228.0	4,000.0	- 772.0	123.9
19	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	5,600.0	7,328.6	- 1,728.6	130.9
20	Газрын төлбөр	370,071.0	345,609.5	24,461.5	93.4
21	Газрын төлбөр	354,071.0	345,609.5	8,461.5	97.6
22	Дуудлага худалдаа	16,000.0	-	16,000.0	-

23	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,096,052.6	937,719.9	158,332.7	85.6
24	Ойн нөөц ашигласны төлбөр	1,077,598.6	932,447.7	145,150.9	86.5
25	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	3,454.0	4,172.2	- 718.2	120.8
26	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	15,000.0	1,100.0	13,900.0	7.3
27	Татварын бус орлого	2,358,490.5	2,107,971.0	250,519.5	89.4
28	Нийтлэг татварын бус орлого	1,142,000.0	891,480.5	250,519.5	78.1
29	Торгуулийн орлого	48,400.0	21,863.6	26,536.4	45.2
30	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	93,600.0	45,049.5	48,550.5	48.1
31	Бусад орлого	1,000,000.0	824,567.4	175,432.6	82.5
32	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,216,490.5	1,216,490.5	-	100.0
33	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	1,216,490.5	1,216,490.5	-	100.0
34	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,334,478.6	5,352,379.6	982,099.0	84.5
35	УРСГАЛ ЗАРДАЛ	6,334,478.6	5,352,379.6	982,099.0	84.5
36	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,334,478.6	5,352,379.6	982,099.0	84.5
37	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,260,071.6	1,110,068.6	150,003.0	88.1
38	Үндсэн цалин	611,630.6	558,656.0	52,974.6	91.3
39	Нэмэгдэл	520,455.3	485,085.2	35,370.1	93.2
40	Урамшуулал	127,985.7	66,327.4	61,658.3	51.8
41	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	157,287.9	139,935.6	17,352.3	89.0
42	Тэтгэврийн даатгал	107,131.3	94,891.1	12,240.2	88.6
43	Тэтгэмжийн даатгал	12,531.1	11,154.2	1,376.9	89.0
44	ҮОМШӨ-ний даатгал	6,295.6	6,010.1	285.5	95.5
45	Ажилгүйдлийн даатгал	6,235.1	5,545.2	689.9	88.9
46	Эрүүл мэндийн даатгал	25,094.8	22,334.9	2,759.9	89.0
47	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	498,832.3	378,217.5	120,614.8	75.8
48	Гэрэл, цахилгаан	58,339.9	39,696.8	18,643.1	68.0
49	Түлш, халаалт	400,079.5	298,131.4	101,948.1	74.5
50	Цэвэр, бохир ус	40,412.9	40,389.3	23.6	99.9
51	Хангамж, бараа материалын зардал	80,154.3	60,983.0	19,171.3	76.1
52	Бичиг хэрэг	13,781.2	7,922.6	5,858.6	57.5
53	Тээвэр, шатахуун	43,613.6	36,788.3	6,825.3	84.4
54	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,616.0	2,141.4	3,474.6	38.1
55	Ном, хэвлэл	5,000.0	3,776.5	1,223.5	75.5
56	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	346.3	-	346.3	-
57	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,797.2	10,354.2	1,443.0	87.8
58	Нормативт зардал	3,065.6	2,939.9	125.7	95.9
59	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,065.6	2,939.9	125.7	95.9
60	Эд хогшил, урсгал засварын зардал	149,645.7	118,815.5	30,830.2	79.4
61	Багаж, техник, хэрэгсэл	61,773.1	61,016.2	756.9	98.8
62	Тавилга	1,691.0	1,691.0	-	100.0
63	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,985.1	6,362.5	- 4,377.4	320.5
64	Урсгал засвар	84,196.5	49,745.8	34,450.7	59.1
65	Томилолт, зочны зардал	16,509.7	12,152.6	4,357.1	73.6
66	Дотоод албан томилолт	16,509.7	12,152.6	4,357.1	73.6
67	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	177,244.8	118,106.2	59,138.6	66.6
68	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	170,379.3	115,197.0	55,182.3	67.6
69	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,002.0	-	1,002.0	-

70	Даатгалын үйлчилгээ	942.0	425.8	516.2	45.2
71	Тээврийн хэрэгслийн татвар	1,607.8	838.5	769.3	52.2
72	Тээврийн хэрэгслийн оношилгоо	301.8	165.0	136.8	54.7
73	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,019.7	484.0	535.7	47.5
74	Газрын төлбөр	906.3	-	906.3	-
75	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	54.2	-	54.2	-
76	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,031.7	995.9	35.8	96.5
77	Бараа үйлчилгээний бусад зардал	1,020,270.5	741,738.1	278,532.4	72.7
78	Бараа үйлчилгээний бусад зардал	1,013,519.4	741,348.1	272,171.3	73.1
79	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,751.1	390.0	6,361.1	5.8
82	Засгийн газрын дотоод шилжүүлэг	382,384.5	382,384.5	-	100.0
84	Бусад урсгал шилжүүлэг	59,062.8	56,382.0	2,680.8	95.5
85	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	59,062.8	56,382.0	2,680.8	95.5
86	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,308,285.6	1,720,248.0	588,037.6	74.5
87	Барилга байгууламж	1,934,860.7	1,460,475.7	474,385.0	75.5
88	Тоног төхөөрөмж	79,000.0	16,350.0	62,650.0	20.7
89	Бусад хөрөнгө	294,424.9	243,422.3	51,002.6	82.7
90	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	169,456.9	110,000.0	59,456.9	64.9
91	Эргэж төлөгдөх зээл	169,456.9	110,000.0	59,456.9	64.9
92	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	3,656,901.6		3,656,901.6	-
94	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	- 3,656,901.6		-3,656,901.6	-
95	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,346,625.7	-1,346,625.7	#DIV/0!
96	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	982,099.6	- 982,099.6	#DIV/0!
97	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	58.0	58.0	-	100.0
98	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.0	2.0	-	100.0
99	Төсвийн байгууллага	2.0	2.0	-	100.0
100	АЖИЛЛАГСДЫН ТОО	28.0	28.0	-	100.0
101	Удирдах ажилтан	6.0	6.0	-	100.0
102	Гүйцэтгэх ажилтан	11.0	11.0	-	100.0
103	Үйлчлэх ажилтан	9.0	9.0	-	100.0
104	Гэрээт ажилтан	2.0	2.0	-	100.0
105	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28.0	28.0	-	100.0
106	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	12.0	12.0	-	100.0
107	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	9.0	9.0	-	100.0
108	Гэрээт ажилтан	2.0	2.0	-	100.0
109	Улс төрийн албан хаагч (УТ)	5.0	5.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,766,226.1	1,766,226.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,766,226.1	1,766,226.1
122	Тусламжийн орлого	1,766,226.1	1,766,226.1
1221	Хандив тусламж /дотоод/	1,766,226.1	1,766,226.1
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,766,226.1	1,766,226.1

350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,084.3	43,084.3
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,723,141.8	1,723,141.8
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,760,293.3	1,760,293.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,760,293.3	1,760,293.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,760,293.3	1,760,293.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	514.5	514.5
210104	Урамшуулал	514.5	514.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59.2	59.2
210201	Тэтгэврийн даатгал	40.2	40.2
210202	Тэтгэмжийн даатгал	4.7	4.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	9.5	9.5
210204	Ажилгүйдлийн даатгал	2.4	2.4
210205	Эрүүл мэндийн даатгал	2.4	2.4
2104	Хангамж, бараа материалын зардал	37,063.1	37,063.1
210401	Бичиг хэрэг	910.0	910.0
210402	Тээвэр, шатахуун	19,558.1	19,558.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	120.0	120.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,475.0	16,475.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,000.0	2,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000.0	2,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,720,656.5	1,720,656.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,720,656.5	1,720,656.5
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	5,932.8	5,932.8
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	- 5,932.8	- 5,932.8
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	- 5,932.8	- 5,932.8

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Төсвийн байгууллагад ном хэвлэлийн зардал, дүрэмт хувцас худалдаж авахгүй байх, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлдэхгүй байхад хяналт тавьж ажилласан,*
- *Албан хэрэг хөтлөлтийг цахимжуулж бичиг хэргийн зардлыг бууруулсан,*
- *Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй байна.*

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 35 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад сумын ИТХ нь спортын уралдаан, тэмцээн зохион байгуулахад нийт **470.0** мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.8: *байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

2025 оны сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт **65,630.1** мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс **14,161.4** мянган төгрөгийн алдааг залруулж, **50,998.5** мянган төгрөгийн **6** зөрчилд албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх **1** зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар **470.0** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, **1** зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

Үүнээс:

1. Бие даасан дүгнэлт өгсөн ААТҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар:

Сумын ТТЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдэж, бие даасан дүгнэлт өгсөн Хүдэр сумын “Ой анги” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудиттай холбоотой зөрчилд **1 албан шаардлага** өгсөн.

2. Сумын ТТЗ-ийн түвшний санхүүгийн тайлангийн аудитаар:

Аудитаар 8 ширхэг үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацааг дутуу оруулснаас шалтгаалан зардлыг **14,161.6** мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн алдааг аудитын явцад залрууллаа.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд

УСНББОУС-1: “Санхүүгийн тайлангийн толилуулга”, УСНББОУС-17: “Үндсэн хөрөнгө” болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **50,998.5** мянган төгрөгийн 7 зөрчил илэрч, 50,998.5 мянган төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **51,468.5** мянган төгрөгийн материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс **12,456.7** мянган төгрөгөөр бага тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага:

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2021 онд үйлдвэрлэгдэж, Монгол Улсад орж ирсэн Land 76 маркийн /зах зээлийн үнэ ойролцоогоор 125.0-130.0 сая төгрөг/ автомашиныг 140,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан буюу зах зээлийн бодит үнээс **10,000.0** мянган төгрөгөөр илүү үнээр худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

Сумын Засаг даргын Тамгын газар:

2. Сумын ЗДТГ-ын нярав Б.Нармандахын хувийн харилцах дансанд **19,882.0** мянган төгрөгийг шилжүүлэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу болон баримтгүйгээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэв.

3. Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлсийн зардлаас бичиг хэргийн материал худалдан авах зэрэгт нийт **650.6** мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг зардлын арга хэмжээ, бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв*

гаргах үндэслэл болно” гэсэн заалтууд буюу Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

4. Сумын ИТХ-ын мэргэжилтэн М.Цэнд-Аюушийн хувийн харилцах дансанд **4,934.7** мянган төгрөгийг шилжүүлэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу болон баримтгүйгээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэв.

5. Бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлаас нэг удаагийн тэтгэмжид **500.0** мянган төгрөг олгож, батлагдсан төсвийг зардлын хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй зөрчлийг гаргасан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтууд буюу Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

“Хүдэр тохижилт” ОНӨААТҮГ:

6. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааг зохистой удирдаагүй, санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийж, бодлого менежментийг зөв тогтоогоогүйгээс **15,031.2** мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж, өөрөө өөрийгөө санхүүжүүлж чадахгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “*Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйл ажиллагааныхаа орлогоор өөрийгөө санхүүжүүлж чадахгүй, ихээхэн хэмжээний алдагдалтай ажиллаж буй тус газрын асуудлыг сумын ИТХ-аар хэлэлцүүлэх, холбогдох арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж:

1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Хамтарсан багийн үйл ажиллагааны зардлыг ЗДНХ-ийн арга хэмжээнд, нохой устгалын зардлыг үндсэн үйл ажиллагааны арга хэмжээнд тусгаж, зарцуулан тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2: “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 42 дугаар зүйлийн 42.3.1 дэх “Төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид, ...хүргүүлэх”, гэсэн заалтууд болон УСНББОУС-1: “Санхүүгийн тайлангийн толилуулга” болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн төлөвлөлтийг хууль, журмын дагуу үнэн зөв төлөвлөх, шаардлагатай тохиолдолд төсөвт зохицуулалт хийлгэж байх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	2	10,000.0			1	10,000.0	1					
ИТХ	2	5,434.7			2	5,434.7						
ЗДТГ	3	20,532.6			2	20,532.6						
Хүдэр тохижилт	1	15,031.2			1	15,031.2						
Сумын ТТЗ-ийн дүн	8	50,998.5			6	50,998.5						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Төсвийн хөрөнгөөр тэмцээн зохион байгуулсан	1	470.0			1	470.0		
Нийт дүн	1	470.0			1	470.0		